

## Тойм ба үндэслэл

<p><b>Үзүүлэлт</b></p>	<p><b>15. СББӨ болон түүнийг хамгаалахын ач холбогдлыг холбогдох олон нийт, бүлгүүд, хувь хүмүүс болон нийгэм даяар хүлээн зөвшөөрдөг эсэх.</b></p>	
<p><b>Үнэлгээний хүчин зүйлүүд</b></p>	<p>Энэхүү үзүүлэлтийг оролцогч талуудаар хянуулж, тайланг үндэсний түвшний гурван хүчин зүйл дээр үндэслэн үнэлдэг::</p>	
	<p>15.1 Олон нийт, бүлгүүд, хувь хүмүүс СББӨ-өө өөрсдийн сайн сайхан байдлын төлөө, ялангуяа тогтвортой хөгжлийн хөтөлбөрүүдийн хүрээнд ашигладаг.</p>	
	<p>15.2 Олон нийт, бүлгүүд, хувь хүмүүс СББӨ-г хоорондын харилцан хүндэтгэл үүсгэх, зөрчилдөөныг шийдвэрлэх, энх тайвныг тогтооход дэмжлэг үзүүлэх зорилгоор ашигладаг.</p>	
	<p>15.3 Хөгжил дэвшлийн явц дахь хөндлөнгийн оролцоо, арга хэмжээнүүд нь СББӨ-ийн нийгэм дэх ач холбогдлыг танин мэдэх, тасралтгүй байдал, мэдлэг, ур чадварын эх сурвалж болгон хүлээн зөвшөөрүүлж, тогтвортой хөгжлийг хангах нөөц болох үүргийг бэхжүүлдэг.</p>	<p>OD 170, OD 173</p>
<p><b>ТХЗ болон бусад үзүүлэлтүүд тэй холбогдох нь</b></p>	<p><b>Тогтвортой хөгжлийн зорилтууд:</b> Энэ үзүүлэлтийн тогтвортой хөгжил ба сайн сайхныг баримталсан байдал, анхаарал хандуулж буй нь ТХЗ-ын Зорилт 1(Бүх хэлбэрийн ядуурлыг хаа сайгүй зогсоох), ТХЗ-ын Зорилт 2(Бүх насны хүн бүрийн эрүүл амьдралыг хангах, сайн сайхан байдлыг дэмжих') зэрэг зорилтуудыг дэмжиж байдаг. ТХЗ-ын 9.1-д “Хүн төрөлхтний сайн сайхан байдлыг дэд бүтэц”-ийн хувьд мөн авч үзсэн бол зөрчил мөргөлдөөнийг шийдвэрлэх, энх тайвныг бэхжүүлэх нь ТХЗ-ын 16.2-д заасан “хууль дээдлэх ёсыг хөхиүлэн дэмжиж, шударга ёсыг хүн бүрт тэгш хүртээмжтэй байлгах” зорилтын нэг хэсэг юм. Бусад бүх үзүүлэлтүүдийн адилаар энэхүү үзүүлэлт нь “Дэлхийн соёлын болон Байгалийн өвийг хамгаалах, хадгалах хүчин чармайлт”-ыг бэхжүүлэх замаар ТХЗ-ын 11.4 зорилтыг дэмжиж байна.’</p>	

	<p><b>Бусад үзүүлэлтүүдийн хамаарал:</b> Үзүүлэлт 11-14 нь бодлогийн орчныг илэрхийлж байгаа бол харин 15-р үзүүлэлт нь бодлого, хууль эрх зүйн болон захиргааны арга хэмжээ хэрхэн үр дүнтэй хэрэгжиж байгааг харуулж байдаг.</p>
<p><b>Үйл ажиллагааны үндэслэл</b></p>	<p>Нийгэмд СББӨ-ийн ач холбогдлыг онцолж буй энэ үзүүлэлт нь тогтвортой хөгжил, хүн төрөлхтний сайн сайхан байдалд СББӨ хэрхэн хувь нэмэр оруулж болохыг харуулдаг. Энэ нь хүний эрх, нийгмийн шударга ёсны чухал хэмжүүрүүдийг өөртөө агуулдаг. Энэхүү конвенцид “Соёлын биет бус өвийн нийгэмд нөлөө үзүүлэх үйл ажиллагааг дэмжих, уг өвийг хамгаалах асуудлыг төлөвлөлтийн хөтөлбөрт тусгахад чиглэсэн ерөнхий бодлого” батлах тухай өгүүлдэг (13-р зүйлийн а). Гэсэн хэдий ч бодлого боловсруулах, хөгжил дэвшилт төлөвлөлт нь хийсвэр дадлага биш, харин хөтөлбөр, үйл ажиллагаа болгон хөрвүүлж, хэрэгжүүлж байж үр дүнд хүрдэг гэдгийг санах нь зүйтэй. Тэгэхээр шалгуур нь энд ийм бодлого байгаа эсэх нь чухал биш, харин СББӨ нь хүмүүсийн сайн сайхан байдлыг сайжруулахад ашиглагдаж байгаа эсэх явдал юм.</p>
<p><b>Гол нэр томъёо</b></p>	<ul style="list-style-type: none"> <li>· Олон нийт, бүлгүүд болон зарим тохиолдолд хувь хүмүүс</li> <li>· Тогтвортой хөгжил</li> </ul>

**Хяналт-шинжилгээ хийх, үе үе тайлагнах тухай тусгай заавар**

<p><b>Хяналтын ашиг тус</b></p>	<p>Энэхүү үзүүлэлтэд хяналт тавих нь нийгэм, бүлгүүд, хувь хүмүүс өөрсдийн сайн сайхан байдал, амьдралын чанарыг сайжруулах бодлого, хууль эрх зүйн болон захиргааны арга хэмжээнүүдийн үр шимийг хэр хүртэж байгааг ил тодоор харуулна (Үнэлгээний хүчин зүйл 15.1, 15.2). Түүнчлэн Үнэлгээний хүчин зүйл 15.3-т хяналт тавих нь оролцогч талууд хөгжлийн бодит арга хэмжээнүүд нь бодлогын хүрээндээ тодорхойлсон зорилтуудыг хангаж байгаа эсэх, мөн СББӨ-ийг тогтвортой хөгжлийн эх үүсвэр болгон хэрхэн ашиглаж байгааг шалгаж болно. Энэхүү үзүүлэлтийг хянах нь зэвсэгт зөрчилдөөн тулгарсан эсвэл тулгарч болзошгүй улс орнуудад мөргөлдөөнөөс урьдчилан сэргийлэх болон/эсвэл мөргөлдөөний дараах эвлэрэлд хүргэх арга замд хүрэхэд хувь нэмрээ оруулж чадна. Дэлхийн хэмжээнд хяналт шинжилгээ хийснээр дэлхий даяар улс орнуудад хэрэгжүүлж буй бүтээлч стратеги, арга хэмжээг тодорхойлж, үр дүнтэй чанартай туршлагын жишээг бий болгож, улмаар олон улсын хамтын ажиллагаа, солилцооны боломжуудыг бүтээж чадна.</p>
<p><b>Мэдээллийн эх сурвалж, цуглуулга</b></p>	<p>Мөн хяналт тавих ба тайлагнах үүрэг хүлээсэн хүмүүс СББӨ-тэй холбоотой үйл ажиллагааны баталгаатай жишээ олж тогтоохын тулд илүү өргөн хүрээний мэдээллийн эх сурвалжуудыг судлах шаардлагатай байж магадгүй. СББӨ-ийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг оролцогч талуудын дунд үе үе санал асуулга явуулах, эсвэл хэвлэл мэдээллийн хэрэгслээр цацагдаж буй мэдээлэллийг ашиглах, эрдэм шинжилгээний судалгааны тойм зэргийг судлах нь мэдээлэл цуглуулах чухал хэрэгсэл байж болно. Хэрэв өргөн хүрээг хамарсан зөвлөлдөх байгууллага эсвэл зохицуулах механизм байгаа бол энэ нь үзүүлэлтүүдийн мэдээллийн чухал эх сурвалж болно.</p> <p><b>Боломжит мэдээллийн эх сурвалжууд</b></p> <ul style="list-style-type: none"> <li>· ТББ, олон нийтийн холбоо болон бусад оролцогч байгууллагуудын үйл ажиллагааны талаарх тайлан</li> <li>· Мэргэжлийн холбоодын вэбсайтууд эсвэл судлаачдын сүлжээ ба мэдээллийн товхимолууд</li> <li>· Олон нийтэд түшиглэсэн санаачилга эсвэл бусад хамгаалалтын арга хэмжээний талаар хэвлэл мэдээллийн хэрэгсэл дээрх мэдээллүүд</li> </ul>